



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.04.20 № 168

танай _____ -ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
З.БАТЗОРИГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Булган, Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсвийн 13 шууд захирагч нийт 17 санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", аймгийн Нөөцийн газрын санхүүгийн тайланд "Татгалзсан" дүгнэлт тус тус өгөгдсөн,

006020355

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль, Уньт бага сургууль, Хантай бага сургууль нь НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг зөрчиж, жилийн эцсийн санхүүгийн тайланг стандарт, санхүүгийн программаар гаргаагүй, аудитын түүвэрлэлт хийх хангалттай, зохистой нотлох баримт олж авах боломжгүй, баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдал хангалтгүй тул төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд санхүүжилтийн 1372.0 сая төгрөгөөр алдаа, зөрчил тооцсон,

Аймгийн байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлангаар 242.0 сая төгрөгийн 9 сум, "Ленда" ХХК-тай холбоотой нөхөн сэргээлт, ижүүлалтын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, *Б.Омгирал*

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын барагдуулалтад ахиц гараагүй хугацаа хэтэрсэн 526 иргэн, ААН байгууллагын 1883.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, төрийн сангийн авлага 212.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй үүнээс 1996-2002 онуудад үүссэн хүнс, өвс тэжээл, зээл зэрэг 75.3, 2008 онд "Атрын III" аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага 137.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны СТА-аар өгөгдсөн боловч тодорхой ажил зохион байгуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй, *С.Самуулагч*

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөв захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй цалин, урамшууллыг давхардуулан олгосон, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан гэх мэтчилэн нийт 3556.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн зэрэг нь санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэ зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Д.АНХБАЯР* Д.АНХБАЯР

